



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/038/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: antugs.s@auditmn@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Анализ старт Аудит ХХК-ийн захирал Н.Энхтуяа Утас: 99075818 Цахим хаяг: asaudit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
Дараа жилийн санхүүгийн тайлангийн аудитаар:	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нотлох ажил
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 307
танай _____-ны № _____-т

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.МЭНДБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн яамнаас 314.2 сая төгрөгийн, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас 323.3 сая төгрөгийн, Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газраас 19.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллага нь 2025 онд ЭМДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолын дагуу ЭМДЕГ-тай байгуулсан гэрээнд төлөвлөгөөт ангиллын тусламжийг сарын хуваариас хэтэрсэн тохиолдлын 20 хувиар хязгаарлалттайгаар санхүүжүүлснээр тайлант онд цахим хасагдлаар 902.7 сая төгрөгийн орлогыг хасуулсан байна.

Бусад асуудал

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний хүрээнд Нийслэлийн засаг даргын 2025 оны А/1144 дүгээр захирамжийн дагуу Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 689,141.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажил хийж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,068,041,815.81	4,324,193,903.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	384,112,767.84	88,061,378.74
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	384,112,767.84	88,061,378.74
31210	Төгрөг	384,112,767.84	88,061,378.74
31211	Төрийн сангийн харилцах	384,112,767.84	88,061,378.74
33	АВЛАГА	1,563,063,205.62	2,932,745,505.39
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	307,517.02	870,776.02
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,531,907,979.30	2,901,027,020.07
33500	Бусад авлага	30,847,709.30	30,847,709.30
33510	Байгууллагаас авах авлага	30,847,709.30	30,847,709.30
34	УРЬДЧИЛГАА	-	9,230,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	-	9,230,000.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	9,230,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,120,865,842.35	1,294,157,019.83
35100	Түүхий эд материал	641,368,271.67	638,952,566.6
35110	Тусгай зориулалттай материал	41,693,659	41,293,659
35130	Эм боох материал	599,674,612.67	597,658,907.6
35400	Хангамжийн материал	479,497,570.68	655,204,453.23
35410	Бичиг хэргийн материал	21,790,270.00	13,341,510.00
35420	Аж ахуйн материал	108,833,583.85	94,225,238.36
35430	Сэлбэг хэрэгсэл	17,801,000.00	40,194,325.00
35440	Түлш, шатах тослох материал	11,576,761.16	11,669,193.2
35450	Барилгын засварын материал	-	16,636,400.00
35470	Бусад хангамжийн материал	319,495,955.67	479,137,786.67
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,054,675,480.26	9,752,890,843.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,054,675,480.26	9,752,890,843.71
39200	Биет хөрөнгө	9,836,996,760.26	9,501,702,123.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,061,332,031.40	7,061,332,031.4
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,232,213,724.40	-1,596,375,628.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	240,536,081.90	240,536,081.90
39204	Хуримтлагдсан элэгдэл	-171,337,061.78	-186,877,564.22
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,852,867,421.02	6,652,762,248.59
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,109,126,247.48	-2,829,554,042.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	311,485,715.00	293,800,820.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-116,547,455.40	-133,921,822.73
39300	Биет бус хөрөнгө	217,678,720.00	251,188,720.00
39301	Програм хангамж	9,959,570.00	9,959,570.00

39302	Хуримтлагдсан элэгдэл	-9,959,570.00	-9,959,570.00
39303	Бусад биет бус хөрөнгө	217,678,720.00	251,188,720.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	13,122,717,296.07	14,077,084,747.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,763,580,419.65	4,761,327,633.15
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,763,580,419.65	4,761,327,633.15
41300	Өглөг	2,763,580,419.65	4,761,327,633.15
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	325,705,093.39	1,440,079,927.98
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,434,007,576.26	3,226,390,739.17
41360	Бусад өглөг	3,867,750.00	94,856,966.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,782,700.00	94,771,916.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	85,050.00	85,050.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,359,136,876.42	9,315,757,114.52
51	Засгийн газрын хувь оролцоо	10,359,136,876.42	9,315,757,114.52
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,690,475,497.94	2,690,475,497.94
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	2,690,475,497.94	2,690,475,497.94
51200	Хуримтлагдсан үр дүн	4,522,605,215.27	3,479,225,453.37
51210	Өмнөх үеийн үр дүн	2,697,477,904.86	4,522,605,215.27
51220	Тайлант үеийн үр дүн	1,825,127,310.41	-1,043,379,761.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,146,056,163.21	3,146,056,163.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	13,122,717,296.07	14,077,084,747.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	17,871,048,684.96	18,051,152,388.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,328,560,902.36	18,051,152,388.17
120	Нийтлэг татварын бус орлого	5,328,560,902.36	3,981,698,358.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,730,804,072.02	1,638,087,152.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,291,702,949.02	1,145,069,485
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	439,101,123	493,017,667.90
120005	Түрээсийн орлого	844,800.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,888,116,702.30	656,483,751.60
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,708,795,328.04	1,687,127,453.67
122	Тусламжийн орлого	-	14,069,454,030.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	14,069,454,030
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,750,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,750,000.00

12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	14,059,704,030.00
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	14,059,704,030.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,542,487,782.60	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,542,487,782.60	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,542,487,782.60	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	16,045,921,374.55	19,094,532,150.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,045,921,374.55	19,094,532,150.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,738,739,902.21	19,105,171,784.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,343,597,916.52	8,113,089,054.87
210101	Үндсэн цалин	4,107,494,549.26	4,693,783,646.19
210102	Нэмэгдэл	1,925,517,475.08	1,902,831,788.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	588,355,000.00	734,056,000.00
210104	Урамшуулал	722,230,892.18	782,417,620.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	888,156,308.35	953,682,108.36
210201	Тэтгэврийн даатгалын зардал	615,452,951.48	656,263,973.94
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	74,122,297.09	81,949,095.33
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	47,716,351.22	57,029,020.32
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	29,792,178.39	31,125,817.25
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	121,072,530.17	127,314,201.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	230,172,820.88
210301	Гэрэл, цахилгаан	-	112,782,386.16
210302	Түлш, халаалт	-	35,160,714.19
210303	Цэвэр, бохир ус	-	82,229,720.53
2104	Хангамж, бараа материалын зардал	230,760,980.56	425,903,869.81
210401	Бичиг хэрэг	34,676,055.00	70,407,116.00
210402	Тээвэр, шатахуун	9,686,702.90	62,974,367.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,223,011.90	27,830,945.36
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,821,500.00	24,348,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,648,500.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	155,705,210.76	240,342,940.49
2105	Нормативт зардал	5,987,764,654.51	7,860,087,256.23
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,793,481,660.51	7,655,345,667.23
210502	Хоол, хүнс	194,282,994.00	204,741,589.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,642,000.00	23,213,800.00
210604	Урсгал засвар	37,642,000.00	23,213,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	234,781,858.00	395,753,056.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	226,530,858.00	385,918,112.74
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	-	406,944.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,000.00	312,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,017,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,016,036,184.27	1,103,269,817.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,654,000.00	1,685,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,362,810.00	395,705.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	990,019,374.27	1,101,189,112.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	307,181,472.34	-10,639,633.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	307,181,472.34	234,533,186.91
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	296,880,773.34	223,933,186.91
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,300,699.00	10,600,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-245,172,820.88
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-245,172,820.88
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,825,127,310.41	-1,043,379,761.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	1,825,127,310.41	-1,043,379,761.90

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	12,906,560,074.30	14,332,274,400.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,781,723,066.00	14,332,274,400.10
120	Нийтлэг татварын бус орлого	1,781,723,066.00	1,641,689,410.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,781,723,066.00	1,641,689,410.87
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,342,621,943.00	1,148,671,742.97
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	439,101,123.00	493,017,667.9
122	Тусламжийн орлого	-	12,690,584,989.23
1221	Хандив тусламж /дотоод/	-	12,690,584,989.23
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	12,690,584,989.23
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	12,690,584,989.23
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,124,837,008.3	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,124,837,008.3	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,124,837,008.3	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,394,541,696.46	14,529,055,065.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,394,541,696.46	14,529,055,065.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,087,360,224.12	14,294,521,878.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,136,825,305.48	7,257,053,468.75
210101	Үндсэн цалин	3,692,426,473.83	3,856,747,800.16
210102	Нэмэгдэл	2,118,550,385.23	1,885,742,381.81

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	582,706,868.66	734,359,326.24
210104	Урамшуулал	743,141,577.76	780,203,960.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	968,985,411.34	699,436,376.86
210201	Тэтгэврийн даатгалын зардал	713,224,185.29	479,931,220.48
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	64,762,756.89	58,173,698.18
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	37,819,447.51	42,813,774.86
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	25,745,651.99	17,596,844.59
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	127,433,369.66	100,920,838.75
2104	Хангамж, бараа материалын зардал	226,230,089.90	297,469,497.36
210401	1Бичиг хэрэг	42,050,478.00	41,042,435.00
210402	Тээвэр, шатахуун	18,833,600.00	63,066,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,223,011.90	27,830,945.36
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	23,888,000.00	22,976,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	129,235,000.00	142,553,317.00
2105	Нормативт зардал	3,334,371,791.40	5,416,686,884.58
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,066,259,791.40	5,142,488,595.58
210502	Хоол, хүнс	195,079,000.00	247,679,089.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	73,033,000.00	26,519,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	125,709,818.00	155,220,590.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,177,700.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	99,532,118.00	149,220,590.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	244,936,258.00	429,898,255.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	221,537,858.00	403,269,286.74
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	406,944.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,000.00	312,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,614,400.00	9,286,025.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,533,000.00	8,525,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,301,550.00	38,756,805.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,768,740.00	38,361,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,532,810.00	395,705.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	307,181,472.34	234,533,186.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	307,181,472.34	234,533,186.91
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	296,880,773.34	223,933,186.91
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,300,699.00	10,600,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	512,018,377.84	-196,780,665.10
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	135,130,210.00	99,270,724.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	135,130,210.00	99,270,724.00
2200	Дотоод эх үүсвэрээр	135,130,210.00	99,270,724.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	135,130,210.00	99,270,724.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-135,130,210.00	-99,270,724.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	376,888,167.84	-296,051,389.10
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,224,600.00	384,112,767.84
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	384,112,767.84	88,061,378.74

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Устгалын өмнөх			
		1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,690,475,497.94	3,146,056,163.21	2,696,528,156.67	8,533,059,817.82
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	949,748.19	949,748.19
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,690,475,497.94	3,146,056,163.21	2,697,477,904.86	8,534,009,566.01
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,825,127,310.41	1,825,127,310.41
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,690,475,497.94	3,146,056,163.21	4,522,605,215.27	10,359,136,876.42
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,690,475,497.94	3,146,056,163.21	4,522,605,215.27	10,359,136,876.42
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,690,475,497.94	3,146,056,163.21	4,522,605,215.27	10,359,136,876.42
19	Тайлант үеийн үр дүн	-	-	-1,043,379,761.90	-1,043,379,761.90
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,690,475,497.94	3,146,056,163.21	3,479,225,453.37	9,315,757,114.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Ерөнхий данс	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Татаас, санхүүжилтийн орлого	14,313,235,500.00	14,332,274,400.10	-19,038,900.10	100.1
	Улсын төсвөөс	-	-	-	-
	Урсгал	-	-	-	-
	Хөрөнгийн	-	-	-	-

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Нөөц сангаас	-	-	-	-
131001	Орон нутгийн төсвөөс	578,725,300.00	245,172,820.88	333,552,479.12	42.4
	Бусад төсөвт байгууллагаас				
134002	Нийгмийн даатгалын сангаас	12,827,477,800.00	12,690,584,989.23	136,892,810.77	98.9
	Бусад тусгай зориулалтын сангаас	-	-	-	-
	Тусламжийн орлого	-	-	-	-
	Бараа, үйлчилгээний орлого	-	-	-	-
	Өмчийн орлого	-	-	-	-
120004	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	1,485,757,700.00	1,641,689,410.87	-155,931,710.87	110.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	979,893,000.00	1,148,671,742.97	(168,778,742.97)	117.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	505,864,700.00	493,017,667.90	12,847,032.10	97.5
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	14,891,960,800.00	14,577,447,220.98	314,513,579.02	97.9
2100	Ажиллагчидтай холбогдсон зардал	7,812,587,300.00	7,956,489,845.61	-143,902,545.61	101.8
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	7,267,541,200.00	7,257,053,468.75	10,487,731.25	99.9
210101	Цалин	3,917,993,800.00	3,856,747,800.16	61,245,999.84	98.4
210102	Нэмэгдэл	2,372,475,400.00	1,885,742,381.81	486,733,018.19	79.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	275,523,900.00	734,359,326.24	-458,835,426.24	266.5
210104	Урамшуулал	701,548,100.00	780,203,960.54	-78,655,860.54	111.2
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл	545,046,100.00	699,436,376.86	-154,390,276.86	128.3
210201	Тэтгэврийн даатгал	325,540,900.00	479,931,220.48	-154,390,320.48	147.4
210202	Тэтгэмжийн даатгал	58,173,700.00	58,173,698.18	1.82	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	42,813,700.00	42,813,774.86	-74.86	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	17,596,900.00	17,596,844.59	55.41	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	100,920,900.00	100,920,838.75	61.25	100.0
	Бараа, үйлчилгээний урсгал зардал	543,725,300.00	230,172,820.88	313,552,479.12	42.3
2103	Тогтмол зардал	543,725,300.00	230,172,820.88	313,552,479.12	42.3
210301	Гэрэл цахилгааны зардал	206,631,000.00	112,782,386.16	93,848,613.84	54.6
210302	Түлш, халаалтын зардал	98,394,300.00	35,160,714.19	63,233,585.81	35.7
210303	Цэвэр, бохир усны зардал	238,700,000.00	82,229,720.53	156,470,279.47	34.4
2105	Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	5,475,836,900.00	5,390,167,684.58	85,669,215.42	98.4
210502	Хоол	250,365,600.00	247,679,089.00	2,686,511.00	98.9
210501	Эм	5,225,471,300.00	5,142,488,595.58	82,982,704.42	98.4
	Бусад бараа үйлчилгээний зардал	1,443,924,100.00	1,296,668,259.01	147,255,840.99	89.8

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэргийн материал	66,968,000.00	41,042,435.00	25,925,565.00	61.3
210402	Тээвэр, шатахууны зардал	55,361,400.00	63,066,800.00	(7,705,400.00)	113.9
210403	Шуудан холбооны зардал	13,541,700.00	27,830,945.36	(14,289,245.36)	205.5
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,012,500.00	395,705.00	616,795.00	39.1
210406	Жижиг эд хогшил худалдан авах зардал	139,400,000.00	142,553,317.00	(3,153,317.00)	102.3
210503	Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	27,447,600.00	26,519,200.00	928,400.00	96.6
210807	Төлбөр, хураамж, жижиг татварууд	3,456,900.00	-	3,456,900.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	534,600.00	406,944.00	127,656.00	76.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,596,700.00	312,000.00	3,284,700.00	8.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	99,000.00	151,000.00	39.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,194,100.00	9,286,025.00	1,908,075.00	83.0
210801	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	516,601,500.00	432,184,286.74	84,417,213.26	83.7
210809	Маягт хэвлүүлэх зардал	8,625,000.00	8,525,000.00	100,000.00	98.8
210601	Багаж, техник хэрэгсэл	66,740,000.00	71,760,724.00	(5,020,724.00)	107.5
210604	Урсгал засвар	191,994,400.00	164,220,590.00	27,773,810.00	85.5
210405	Бусад зардал	23,333,000.00	22,976,000.00	357,000.00	98.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,444,000.00	42,956,100.00	8,487,900.00	83.5
210304	Байрны түрээсийн зардал	-	-	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	243,240,000.00	223,933,186.91	19,306,813.09	92.1
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал, урамшуулал	11,182,700.00	10,600,000.00	582,700.00	94.8
225501	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	-	-99,270,724.00	-	-
	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	15,276,073,600.00	14,873,498,610.08	402,574,989.92	97.4
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		384,112,767.84	-384,112,767.84	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		88,061,378.74	-88,061,378.74	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,230.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан.

Залруулсан алдаа:

- ЭМЯ-наас ирүүлсэн шийдвэрийн дагуу нэг эх үүсвэрээс худалдан авах эмийн захиалга хийж төлбөрийг шилжүүлсэн боловч санхүүгийн байдлын тайланд урьдчилж гарсан зардал дансанд буруу бүртгэсэн байна.

УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” 27. Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг. Энэ нь УСНББОУС-1, “Санхүүгийн тайлангийн толилуулга” санхүүгийн тайлагналын “ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 4 зөрчил² илэрснээс, 2 зөвлөмж, 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1. Илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо 1 цагийн дундаж хөлсийг буруу тооцоолж 4,836.2 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс илүү олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109.5 “Ажилтныг илүү цагаар, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр шөнийн цагт ажиллуулсан бол энэ хуулийн 109.1, 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс дээр шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно”, Хөдөлмөр нийгмийн хамгааллын Сайдын 2021 оны 12 дугаар сарын 6-ний А/192 тоот тушаалаар батласан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” -ын “2.1.3.нэг цагийн дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо ажилтанд тодорхой хугацаанд олгосон цалин хөлсний нийлбэрийг тухайн хугацаанд ажилласан нийт цагийн тоонд хувааж тооцно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалингийн зардлыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2. Төсвийн хөрөнгөөр шинэ жилийн арга хэмжээнд зориулж 4,700.0 мянган төгрөгийн зардал гаргаж хүнсний материалын зардлаар тусгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” Ерөнхий сайдын 2025 оны “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгаварын 1.3 “Төрийн хэмнэлтийн хуулийг чанд мөрдөж, төсвийн хөрөнгөөр шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэх зэрэг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхгүй байх” дахь заалтыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр шинэ жилийн арга хэмжээ тэмдэглэн гаргасан зардлыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн (731,755.9 мянган төгрөгийн) 54 үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгуулаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” журмын 7.1 “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн 54 үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах талаар саналыг боловсруулж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

2. Орлогын данстай холбоотой

Илрүүлэлт-2: ЭМДС-аас авах авлагаас 2025 онд эмчийн хасагдуулгаар 122,734.6 мянган төгрөгийн орлого хасагдсан нь, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.2-т "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах", 13.1.4-д "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх", 13.1-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эмчийн хасагдуулгаар хасагдсан орлогыг өмнөх оны дүнгээс 20-иос доошгүй хувиар бууруулж ажиллах ажлыг зохион байгуулах, цаашид алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЭМЯ-наас ирүүлсэн шийдвэрийн дагуу нэг эх үүсвэрээс худалдан авах эмийн захиалга хийж төлбөрийг шилжүүлсэн боловч санхүүгийн байдлын тайланд УГЗардал дансанд буруу бүртгэсэн байна.	1	9,230.0			1	9,230.0	1	9,230.0				
Дүн	1	9,230.0			1	9,230.0	1	9,230.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Элэгдлээ нөхсөн 731,755.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй 54 нэр төрлийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгуулаагүй байна.	1	-					1	-					
ЭМД-ын сангаас 2025 онд нийт 14,222.4 мянган төгрөгийн ЭМДС-н санхүүжилтын орлого нэхэмжилснээс 122,734.6 мянган төгрөгийн орлогыг ЭМДҮЗ-ийн 2025-01-23 ны өдрийн 04 тоот тогтоолоор оношийн хамаарал бүхий кодчиллол буруу, ЭМСайдын 2019 оны А/611 тоот тушаалын эмнэлгийн зарим үйлчилгээний анхан шатны баримт дутуу нотолгоотой зэргээс шалтгаалан орлогыг	1	122,734.7					1	122,734.7					

дутуу бүрдүүлсэн байна.												
илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо 1 цагийн дундаж хөлсийг буруу тооцоолж 4,836.6 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс илүү олгосон.	1	4,836.2	1	4,836.2								
Төсвийн хөрөнгөөр шинэ жилийн арга хэмжээнд зориулж 4,700.0 мянган төгрөгийн зардал гаргаж хүнсний материалын зардлаар тусгасан байна.	1	4,700.0	1	4,700.0								
Дүн	4	132,270.9	2	9,536.6			2	122,734.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг мэдээлээгүй, хугацаа хоцроож байршуулсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, Дараа жилийн төсвийн төслийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-					1	-				
Дүн	1	-					1	-				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Цахим дэлгүүрт байршсан 17,784.6 мянган төгрөгийн хөрөнгийг бусад этгээдээс худалдан авсан байна.	1	17,784.6			1	17,784.6						
Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг шалгахад 203,601.7 мянган төгрөгийн төлбөрийн акт хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	203,601.7							1	203,601.7		
Дүн	3	221,386.3			1	17,784.6			1	203,601.7		

